

**ХӨДӨӨ АЖ АХУЙН НЭГДЛИЙН МАЛ АЖ АХУЙН ТАВААРЫН
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, ХЭРЭГЛЭЭ (1960-1990 он)**

Н.АЛТАНТӨГС

Товчлол: Хөдөө аж ахуйн нэгдлийн үйлдвэрлэсэн мал аж ахуйн таваарын анхдагч зах зээл нь улсын бэлтгэл байсан бол түүний үндсэн хэрэглэгч нь БНМАУ-ын болон ЗХУ-ын хөнгөн, хүнсний үйлдвэрүүд байв. Хөдөө аж ахуйн нэгдлүүд таваар үйлдвэрлэгч хэлбэрээр оршин тогтнох үндсэн хүчин зүйл бол Зөвлөлт-Монголын эдийн засгийн интеграци байжээ.

Түлхүүр үг: БНМАУ, нэгдэл, таваарын үйлдвэрлэл, социалист интеграци, хоёрдмол эдийн засаг

Удиртгал: Хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүн

Хөдөө аж ахуйн нэгдэл¹ гэдэг нь БНМАУ-д 1955-1992 онд оршин тогтнож байсан, мал аж ахуй голлон эрхэлдэг социалист аж ахуй юм. БНМАУ-ын мал аж ахуйн салбарт 1960-1990 онд хөдөө аж ахуйн нэгдэл үнэмлэхүй зонхилж байв. Нэгдэл оршин тогтнох хугацаанд түүнд БНМАУ-ын нийт ажиллах хүчний 1/3 нь ажиллаж, мал аж ахуйн бүтээгдэхүүний дийлэнхийг гаргаж байсан эдийн засгийн суурь салбар байв. Малчин өрхийн эдлэхүүний аж ахуйгаас хөдөө аж ахуйн нэгдлийн ялгагдах гол онцлог нь нийтийн өмчид хамаарах олон арван мянган мал сүрэг, төрөөс олгосон эзэмшил газартаа үндэслэн их хэмжээний таваарын бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсанд оршино. Өөрөөр хэлбэл, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг таваарын зорилгоор үйлдвэрлэж байсан явдал юм.

Зах зээлгүй бол аливаа таваар үйлдвэрлэгч оршин тогтнож чадахгүй юм. Хөдөө аж ахуйн нэгдэл нь таваарын үйлдвэрлэл, борлуулалттай салшгүй холбоотой. Хөдөө аж ахуйн нэгдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн зорилго нь бүтээсэн бүтээгдэхүүнээ өөрсдөө хэрэглэх явдал биш, харин худалдан борлуулах

¹ 1934-1955 онуудад байсан *ардын үйлдвэрлэлийн нэгдлээс* чанарын хувьд ялгаатай ойлголт

явдал байж, энэ ч учраас таваар үйлдвэрлэгч болж байв. Хөдөө аж ахуйн нэгдэл нь монголын амиа аргацаасан эдлэхүүний мал аж ахуйг социалист өмчид тулгуурласан таваар үйлдвэрлэгч болгон хувиргасан билээ.

Улс төрийн эдийн засгийн ухааны онолч Ф.Энгельс таваар, түүний үйлдвэрлэлийн талаар “Арилжигдаж байгаа бүтээгдэхүүн бол таваар мөн. Энэ юманд, энэ бүтээгдэхүүнд хоёр хүний буюу хоёр хүй нэгдлийн хоорондын харилцаа, үйлдвэрлэгч хэрэглэгч хоёр нь нэг хүн байхаа больж хоорондоо холбоотой болсон тийм харилцаа тогтсон учраас л тэр нь таваар болж байгаа юм” хэмээн тодорхойлсон² бөгөөд энэ нь Монголын социалист эдийн засгийн түүхийг судлахад холбогдох суурь ухагдахуунуудын нэг юм.

Хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүний борлуулалт, хэрэглээ гэдэг нь Монголын мал аж ахуй таваар үйлдвэрлэгч том аж ахуй хэлбэрээр оршин тогтнох нөхцлийг бүрдүүлэгч эдийн засгийн хүчин зүйл юм. Хөдөө аж ахуйн нэгдлийн мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний борлуулалт гэдэг нь мал, мах, сүү, ноос зэргийг мөнгөн орлого олох зорилгоор худалдахыг хэлнэ. Хөдөө аж ахуйн нэгдлийн мал аж ахуйн бүтээгдэхүүний хэрэглээ гэж хөдөө аж ахуйн нэгдлээс гаралтай мал, мах, сүү, ноос зэрэг бүтээгдэхүүнүүдийг хагас буюу бүрэн боловсруулсан бүтээгдэхүүн болгон хувиргах үйл ажиллагааг ойлгоно. Үүнд мах комбинат, арьс ширний үйлдвэрүүд, хүнсний үйлдвэрүүд, жижиглэнгийн дэлгүүрүүдийн худалдан авалт зэргийг хамруулна.

Хөдөө аж ахуйн нэгдлийн талаар түүх, угсаатны зүй, улс төрийн эдийн засгийн ухааны судлаачдын хийсэн олон тооны судалгаанууд нь ихэнхдээ нэгдлийн дотоод амьдрал, эдийн засгийн ололт амжилт, нэгдэлчдийн соёлын дэвшлийг анхаарч судалсан бөгөөд эдгээр судалгааны дотор таваарын бүтээгдэхүүний борлуулалтыг тусгайлан анхаарсан улс төрийн эдийн засгийн ухааны зарим судалгаа бий.

Эдийн засагч М.Пэлжээгийн Бүгд Найрамдах Монгол Ард Улс дахь таваарын үйлдвэрлэл ба худалдаа (1964 он) бүтээлд Монголын таваарын үйлдвэрлэл үүсч хөгжсөн нь гадаад худалдааны харилцаа бий болсон явдалтай нягт уялдаатай гэж үзээд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болон түүхий эд бэлтгэх, худалдан авах явдал бол хот, хөдөөгийн хоорондын бараа гүйлгээний нэг хэлбэр нь юм хэмээн тодорхойлжээ. Тэрээр улсын бэлтгэлийг хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүний үндсэн худалдан авагч хэмээн заагаад “улсын бэлтгэлийн онцгой ач холбогдол нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг улсын мэдэлд төвлөрүүлэхэд

² Ф.Энгельс, “К.Маркс. Улс төрийн эдийн засгийн ухааныг шүүмжлэх нь”, -- К.Маркс, Ф.Энгельс, *Түүвэр зохиол*, 1-р боть, Улаанбаатар: УХГ, 1969, 573-р тал.

орших юм” хэмээн тодорхойлжээ³. Тэрээр хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүнээс улсын бэлтгэл, улсын бэлтгэлээс экспорт, экспортоос импортын тоног төхөөрөмж ба хэрэглээний таваар шалтгаална хэмээн зурагласан байна.⁴ Түүний судалгаанд улсын бэлтгэлийг экспорттой холбож үзсэн боловч чухам улсын бэлтгэлийн ямар бүтээгдэхүүний хэдэн хувийг, ямар улсад экспортолдгийг тодорхойлсонгүйгээс гадна 1964 онд хийгдсэн судалгаа учраас 1970-1980-аад онд БНМАУ-д өрнөсөн нийгэм-эдийн засгийн суурь өөрчлөлтүүдийг хамраагүй юм.

МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын Дээд Сургуулиас 1974 онд зохион гаргасан “Социалист хөдөө аж ахуйн эдийн засаг” сурах бичиг бол хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүний борлуулалтыг Монголын нөхцөлд марксизм-ленинизмийн үүднээс хамгийн тодорхой тайлбарласан бүтээл юм. Уг бүтээлд тодорхойлсноор, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг төвлөрсөн журмаар бэлтгэх явдал бол хөдөө аж ахуйн таваарын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд найдвартай зах зээл бий болгох ач холбогдолтой ажээ.⁵ Социалист хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийг төр хяналтандаа авч байгаа явдал хот, хөдөөгийн эдийн засгийн холбоосыг хянана гэсэн үг бөгөөд пролетарийн диктатурын оршин тогтнох нэг чухал үндэс гэж ойлгож болох юм. Уг бүтээлд, хөдөө аж ахуйн таваарын бүтээгдэхүүний борлуулалтын гол суваг бол улсын бэлтгэл гэдгийг 1970 оны тоо баримтаар тодорхой харуулж, улсын бэлтгэлийн гол бэлтгэн нийлүүлэгч нь хөдөө аж ахуйн нэгдлүүд болохыг мөн онцолжээ. Гэвч тус сурах бичигт улсын бэлтгэлд цугларсан мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүнүүдийг улс юунд зориулж, хэрхэн хэрэглэж байсныг дэлгэрүүлээгүй учир хөдөө аж ахуйн нэгдлийг таваарын аж ахуй болгож байсан үндсэн хэрэглэгчид бүрхэгджээ.

Хөдөө аж ахуйн нэгдийн талаар хийсэн түүх, эдийн засаг, угсаатны зүйн бидний олж үзсэн ихэнх судалгаанд, хөдөө аж ахуйн нэгдэл бол таваарын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч бөгөөд түүний анхдагч худалдан авагч нь улсын бэлтгэл гэдгийг товч тодорхой тэмдэглэж ирсэн боловч, түүний хоёрдогч борлуулалтын бүтэц, түүний эцсийн хэрэглээг тун бүрхэг маягаар тэмдэглэдэг байна. Өөрөөр хэлбэл, улсын бэлтгэл нь Засгийн газрын мэдэлд их хэмжээний нөөцийг бүрдүүлж, тэр нь бүх монголчуудын аж амьдралд хэрэгтэй бүтээн байгуулалтад зориулагдаж

³ Пэлжээ, М., *Бүгд Найрамдах Монгол Ард Улс дахь таваарын үйлдвэрлэл ба худалдаа*, Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл, 1964, 16-р тал.

⁴ Пэлжээ, М., *Бүгд Найрамдах Монгол Ард Улс дахь таваарын үйлдвэрлэл ба худалдаа*, Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл, 1964, 103-р тал.

⁵ *Социалист хөдөө аж ахуйн эдийн засаг*, Улаанбаатар: УХГ, 1974, 256-259-р тал.

байсныг бүгд мэдэж байсан хэдий ч, тэр процесс нь хэрхэн, яаж явагдаж байсан талаар нухацтай судалгаа хийгдэлгүй эдүгээ хүрчээ.

АНУ-ын судлаач Мюрфи “Зөвлөлт Монгол: Улс төрийн анхны дагуул улсын тухай судалгаа” бүтээлдээ хэдийгээр хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүнийг авч үзээгүй боловч түүнтэй нягт уялдаа бүхий Зөвлөлт-Монголын худалдааны харилцааг, түүний дотор БНМАУ-ын мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг онцгой анхаарчээ. Тэрээр Зөвлөлтийн анхны дагуул улс болсноос хойшхи дөчин жилийн хугацаанд БНМАУ-д өрнөдийн улсуудын колоничлолд байсан буурай хөгжилтэй улсуудтай адил төстэй “хоёрдмол эдийн засаг” тогтсон хэмээн үзэж байна.⁶ Энэ үзлээр бол, хөдөө аж ахуйн нэгдлүүдийн борлуулалтын зах зээл нь ЗХУ-д гаргах экспорттой салшгүй холбоотой гэж тайлбарлагдах болно. Гэвч хоёрдмол эдийн засгийн тухай асуултыг БНМАУ-ын түүхийн социалист үед нягтлан үзсэн судалгаа одоогоор алга.

Энэ өгүүлээр хөдөө аж ахуйн таваарын бүтээгдэхүүний борлуулалтын гол сувгууд, тэдгээрийн төгсгөлд орших үндсэн хэрэглэгчийг тодорхойлох, түүнд ЗХУ-д гаргах экспорт болон дотоодын үйлдвэрүүдийн худалдан авалт ямар байр суурь эзэлж байсныг тодруулахыг зорив. Хөдөө аж ахуйн нэгдлүүдийн таваарын бүтээгдэхүүнийг борлуулж байсан зах зээлийг тодорхойлж, түүний хэрэглээг шинжилснээр бид төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг дахь хөдөө аж ахуйн нэгдлүүдийн байр суурийг илүү тодорхой ойлгох, улмаар өнөөгийн Монгол Улсын капиталист эдийн засаг дахь эдлэхүүний мал аж ахуйнуудад үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнүүдийн дотор таваарлаг шинж чанарыг нь нэмэгдүүлэхэд хэрэг болохуйц туршлага илрүүлэх боломжтой юм.

⁶ Хоёрдмол эдийн засаг (dual economy) гэдэг нь хоорондоо харилцан хамаарал багатай хоёр салбар голлосон эдийн засгийг хэлнэ. Энэ хоёр салбарт 1-рт, хэмжээгээр бага, хөрөнгө зарцуулагддаг боловч ажиллах хүч хэмнэдэг шинжтэй үйлдвэрийн салбар, 2-рт, хэмжээгээр том, ажиллах хүч зарцуулагддаг боловч хөрөнгө хэмнэдэг шинжтэй хөдөө аж ахуйн салбарууд орно. Үйлдвэрийн салбар хэмжээгээр жижиг боловч үндэстний бүтээгдэхүүнд хөдөө аж ахуйн салбараас илүү жин дарж болдог ба “эзэн” улстайгаа хийх гадаад худалдаа улсынх нь эдийн засгийг тодорхойлж байдаг хэмээн тайлбарлажээ. Тэрээр энэ тайлбараа Сталины үеийн БНМАУ-д ихэвчлэн хамаарах бөгөөд цаашид тус улсад хоёрдмол эдийн засаг нь хөгжиж буй эдийн засгаар солигдож магадгүй хэмээн үзсэн байна. Мюрфи болон өрнөдийн бусад судлаачдын зүгээс БНМАУ-ын эдийн засгийг энэ мэтээр Монгол-Зөвлөлтийн худалдаа, тусламжийн харилцаатай нягт уялдуулан тайлбарладаг явдал нь нэгдлийн таваарын бүтээгдэхүүний борлуулалтыг судлахад анхаарах ёстой аргагүйн чухал хандлага юм. Дэлгэрэнгүйг: George G.S. Murphy, *Soviet Mongolia: A Study of the Oldest Political Satellite*, Berkeley and Los Angeles: University of California Press, 1966, pp. 187-д үз.

Хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын борлуулалт

Нэгдэл гэдэг нэр БНМАУ-д анх 1934 оноос эхлэн *ардын үйлдвэрлэлийн нэгдэл* гэсэн хэлбэрээр бий болсон бөгөөд энэ үедээ энгийн хоршооны утгатай байв. Харин 1955 оны 5-р сард Хөдөө аж ахуйн нэгдлийн тэргүүний сайчуулын улсын анхдугаар их хурлаас Нэгдлийн үлгэрчилсэн шинэ дүрмийг баталснаар *хөдөө аж ахуйн нэгдэл* гэдэг ойлголт бий болжээ.⁷ Хөдөө аж ахуйн нэгдлийн талаар 1973 оны БНМАУ-ын хөдөө аж ахуйн нэгдлийн үлгэрчилсэн дүрэмд дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

*Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хоршооллын дээд хэлбэр болсон хөдөө аж ахуйн нэгдэл бол хамтын хөдөлмөрөөр нийгмийн үйлдвэрлэлийг эрхлэхийн тул БНМАУ-ын үндсэн хуульд бүрэн нийцүүлэн сайн дурын үндсэн дээр байгуулсан хөдөлмөрчин ардуудын хоршоолсон социалист аж ахуй мөн.*⁸

БНМАУ-ын мал аж ахуйд 1960 оноос эхлэн хөдөө аж ахуйн нэгдэл зонхилох болж, энэ нь БНМАУ-ын эдийн засагт “социалист үйлдвэрлэлийн харилцаа ялсны” гол баталгаа гэгдэж байв. Хөдөө аж ахуйн нэгдэл нь БНМАУ-ын нийт мал сүргийн 80 орчим хувийг эзэмшиж байсан бол удаад нь иргэдийн амины мал орж, харин сангийн аж ахуй болон албан байгууллагуудын мал маш цөөн хувийг эзэлж байв.

БНМАУ-ын мал аж ахуйн салбаруудын малын тоо, мянган толгой

	1960	1970	1980
Хөдөө аж ахуйн нэгдэл	16968.8	16531.5	18086.8
Сангийн аж ахуй	475.3	896.6	1335.4
Улсын бусад байгууллагууд	141.3	141.2	187.9
Амины мал	5415.1	5005.6	4161.3
Нийт	23000.5	22574.9	23771.4

Эх сурвалж: *Народное хозяйство МНР за 60 лет, юбилейный статистический сборник*, Улан-Батор, 1981, сс.181.

Хөдөө аж ахуйн нэгдлүүд 1979 оны судалгаагаар улсын дунджаар төрөл бүрийн 64.0 мянган толгой мал, түүний дотор 1.8 мянган тэмээ, 4.3 мянган адуу, 4.0 мянган үхэр, 40.6 мянган хонь, 13.3 мянган ямаатай байв.⁹ Энэ нь хөдөө аж ахуйн нэгдлүүд олон мянган толгой мал, үйлдвэрлэлийн өргөн нөөц бололцоотой томоохон аж ахуйнууд болон хувирсныг харуулна.

⁷ *БНМАУ-ын түүх*, Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл, 1966, 443-р тал.

⁸ *Хөдөө аж ахуйн нэгдлийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн эмхтгэл*, Улаанбаатар: УХГ, 1988, 11-р тал.

⁹ Балжинням, Д., Шагдар, Я., *БНМАУ-ын хөдөө аж ахуйн нэгдэл*, Улаанбаатар: УХГ, 1979. 30-р тал.

Хөдөө аж ахуйн нэгдэл нь улсын нийт мал сүргийн ихэнхийг эзэмшиж байсан ба энэ утгаараа мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний үндсэн үйлдвэрлэгч байв. Нэгдлүүд 1960 оноос эхлэн улс орны дотор бэлтгэж байгаа мал аж ахуйн таваар бүтээгдэхүүний 3/4 хувийг нийлүүлдэг болсон байв.¹⁰

Хөдөө аж ахуйн нэгдлийн үйлдвэрлэн гаргаж байсан үндсэн бүтээгдэхүүнүүд нь мал, мах, ноос, ноолуур, сүү, арьс шир зэрэг мал аж ахуйн гаралтай зүйлсээс бүрдэнэ. Хөдөө аж ахуйн нэгдлүүд улсад 1965 оны байдлаар 120.6 мянган тонн мах, 17.8 мянган тонн бүх төрлийн ноос, ноолуур, 77.2 мянган тонн сүү тушаажээ.¹¹ 1979 оны байдлаар хөдөө аж ахуйн нэгдлийн үйлдвэрлэсэн мал аж ахуйн бүтээгдэхүүний 60-70 хувийг хонь, үхэр, ямааны мах, 20-30 хувийг ноос, ноолуур, 5-7 хувийг сүү эзэлж байв. Махан бүтээгдэхүүнийг үзвэл, тэмээний мах 2.0 хувь, адууны мах 3.9 хувь, үхрийн мах 21.6 хувь, хонины мах 62.3 хувь, ямааны мах 10.2 хувийг тус тус эзэлж байв. Нэгдлийн нэг жилд үйлдвэрлэсэн махны 93.5 хувь нь таваарт борлогдож байсны дотор хонь, үхрийн мах 84.9 хувийг эзэлж байв.¹²

Хөдөө аж ахуйн нэгдлийн нэг жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 60 орчим хувийг улс, орон нутгийн бэлтгэлд, 10 орчим хувийг зах зээлд, 10 гаруй хувийг гишүүд, албан хаагчдад, 10 хувийг дахин боловсруулалтад, үлдсэнийг үйлдвэрлэлийн дотоод хэрэгцээнд зарцуулж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 80 гаруй хувийг ямар нэг хэлбэрээр борлуулж байв.¹³

Ийм ч учраас хөдөө аж ахуйн нэгдлийн мөнгөн орлогын үндсэн эх үүсвэр нь мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлого байв.

		Онууд				
		1959	1965	1970	1975	1977
Бүх орлого		159.2	541.9	559.3	835.4	732.8
Хувь		100	100	100	100	100
Үүдэс	Мал аж ахуй	111.4	435.0	472.9	738.0	625.8
	Хувь	70.0	80.5	84.0	88.4	85.4
	Газар тариалан	5.7	27.9	14.3	24.4	26.8
	Хувь	3.0	5.2	2.0	2.9	3.7
	Бусад орлого	42.1	78.0	72.0	73.0	80.7
	Хувь	26.4	14.3	12.9	8.7	10.9

Эх сурвалж: Д.Балжинням, Я.Шагдар, *БНМАУ-ын хөдөө аж ахуйн нэгдэл*, Улаанбаатар: УХГ, 1979. 61-р тал.

¹⁰ *БНМАУ-ын түүх*, Улаанбаатар, 1966, 450-р тал.

¹¹ *Хөдөө аж ахуйн нэгдэл, статистикийн эмхтгэл (1959-1965)*, Улаанбаатар, 1967, 32-33-р тал

¹² Балжинням, Д., Шагдар, Я., *БНМАУ-ын хөдөө аж ахуйн нэгдэл*, Улаанбаатар: УХГ, 1979. 64-р тал.

¹³ Балжинням, Д., Шагдар, Я., *БНМАУ-ын хөдөө аж ахуйн нэгдэл*, Улаанбаатар: УХГ, 1979. 64-р тал.

1960 оны байдлаар БНМАУ-ын нийт хөдөө аж ахуйн нэгдлүүдийн мөнгөн орлогын нийлбэр тухайн оны үнээр нийт 257.9 мянган төгрөг байснаас зөвхөн мал аж ахуйгаас 189.9 мянган төгрөгийн орлого олж байсан бөгөөд мал аж ахуйн орлого нийт орлогын 73.5 хувийг эзэлж байв.¹⁴ Харин 1965 он болоход хөдөө аж ахуйн нэгдлийн бүх мөнгөн орлогын 80.4 хувийг мал аж ахуйн орлого эзлэх болж өсчээ. Энэ орлогыг дотор нь задлан авч үзвэл, улсад худалдсан зүйлийн орлого (буюу улсын бэлтгэлд тушаасны орлого) нь хөдөө аж ахуйн нэгдлийн нэг жилийн нийт мөнгөн орлогын 58.9 хувийг, үүний дотор зөвхөн мал, мах борлуулсны орлого дангаараа 63.9 хувийг эзэлж байв.¹⁵ Энэ байдлыг Архангай аймгийн Ихтамир сумын Гэрэлт зам нэгдлээр жишээ болгон авч үзье.

*Архангай аймгийн Ихтамир сумын Гэрэлт зам нэгдлийн
борлуулалтын мөнгөн орлого*

(мянган төгрөгөөр)

	1969		1970		1971	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Мал аж ахуй	2,623.3	81.7	2,496.5	80.1	2,653.8	81.5
Газар тариалан	33.8	1.2	117.6	4.4	143.8	4.4
Хөдөө аж ахуйн дүн	2,657.1	82.8	2,614.1	83.8	2,797.6	85.9
Аж үйлдвэрийн салбар	165.2	5.2	112.9	3.7	195.2	6.1
Туслах үйлчлэх салбар, бусад орлого	385.8	12.0	392.0	12.5	261.3	8.0
Нийт дүн	3,208.1	100	3,119.0	100	3,254.1	100

Эх сурвалж: Архангай аймгийн архивын тасаг, ф-38, д-1, хн-40, 80-р хуудас (товчлон авав)

Гэрэлт зам нэгдлийн бүх мөнгөн орлогын 80-81 хувь нь дан ганц мал аж ахуйгаас үйлдвэрлэсэн таваарын бүтээгдэхүүнийг борлуулснаас орж байв.

1976 он болоход орлого дахь улсын бэлтгэлийн эзлэх хувь хэмжээ улам нэмэгдэж, хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүний борлуулалтын 74.7 хувийг улс, орон нутгийн бэлтгэл, 10.8 хувийг зах зээл, 14.5 хувийг гишүүд, албан хаагчдад худалдсан борлуулалт эзлэх болжээ.¹⁶ Улсын бэлтгэлээс нэгдлүүдэд орох орлого нь 1977 онд 1959 оныхоос 5.6 дахин өссөн байна.¹⁷

Хөдөө аж ахуйн нэгдлүүд нь 1960 оноос эхлэн БНМАУ-ын мал сүргийн дийлэнхийг эзэмшиж, мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний ихэнхийг үйлдвэрлэх болжээ. Хөдөө аж ахуйн нэгдлийн анхдагч худалдан авагч нь улсын

¹⁴ МУУТА, ф-8, д-3, хн-551, 45-р хуудас.

¹⁵ *Хөдөө аж ахуйн нэгдэл, статистикийн эмхтгэл (1959-1965)*, Улаанбаатар, 1967, 47-49-р тал

¹⁶ Д.Балжинням, Я.Шагдар, *БНМАУ-ын хөдөө аж ахуйн нэгдэл*, Улаанбаатар: УХГ, 1979. 64-р тал.

¹⁷ Д.Балжинням, Я.Шагдар, *БНМАУ-ын хөдөө аж ахуйн нэгдэл*, Улаанбаатар: УХГ, 1979. 31-р тал.

бэлтгэл байв. Хэрэв улсын бэлтгэл зогсвол хөдөө аж ахуйн нэгдлийн мөнгөн орлого 70-80 хувиар огцом унах, борлуулалтын шинэ зах зээл олж чадаагүй нөхцөлд хөдөө аж ахуйн нэгдлүүд нийтээрээ оршин тогтнох аргагүй болох ажээ. Улсын бэлтгэл ба хөдөө аж ахуйн нэгдлүүд нь хоорондоо таваарын худалдаагаар ийнхүү нягт уялдсан байв.

Хөдөө аж ахуйн нэгдэл ба улсын бэлтгэл

Бид хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүний борлуулалтад улсын бэлтгэл зонхилж байсныг үзлээ. Тэгвэл улсын бэлтгэл гэж юу болох, ямар цар хүрээтэй байсан, түүний гол ханган нийлүүлэгч нь хэн байсныг нягталъя.

Улсын бэлтгэл гэдгийг тухайн цаг үедээ социалист худалдааны нэг хэлбэр гэж үзэж, “тус орны худалдааны гүйлгээнд хөдөө аж ахуйн таваарын бүтээгдэхүүнийг татан оруулахыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний улсын бэлтгэл” гэж тодорхойлж байв.¹⁸ Үүгээр бол “улсын бэлтгэл” нь худалдаа болж байна. БНМАУ дахь улсын бэлтгэлийн түүхийг үндсэн гурван үечлэлд хуваан үзнэ. Үүнд

- Сайн дурын бэлтгэл (1931-1940)
- Албан журмын бэлтгэл (1941-1959)
- Улсын төлөвлөгөөт бэлтгэл (1960-1990)

Улсын бэлтгэл нь худалдаан дахь төрийн монополь эрхийн үндсэн дээр 1931 онд бий болсон бөгөөд 1941 оноос эхлэн албан журмын хэлбэрт шилжиж, малчид улсад заагдсан тооны мал, түүхий эдийг хямд үнээр заавал тушаах, эс тушааваас хуулийн хариуцлага хүлээх ёстой болов. Мал сүргийг нийгэмчилж дууссан 1959 оныг хүртэл улсын албан журмын бэлтгэл оршин тогтнож, малчдын хувийн өмчийн мал сүрэгт хүнд дарамт болж байв.¹⁹

1959 онд албан журмын бэлтгэлийн системийг бүрэн халж, 1960 оноос эхлэн мал аж ахуйн бүтээгдэхүүнийг улсад худалдан авах системд шилжив. Ингэснээр хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйнуудад бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөт даалгаврыг улсаас жил тутам өгч, түүнд үндэслэн нэг толгой мал ба нэг га талбай тус бүрээс авах бүтээгдэхүүний нормыг тогтоож, уг нормын дагуу бүтээгдэхүүнийг улсад худалдах болов.

Улсын бэлтгэл нь мал, сүү, ноос, арьс шир, ангийн үс, яс, өөх тос ба элдэв хаягдлууд зэрэг олон төрлөөс бүрдэж байв. 2-р таван жилийн төлөвлөгөөний

¹⁸ М.Пэлжээ, *Бүгд Найрамдах Монгол Ард Улс дахь таваарын үйлдвэрлэл ба худалдаа*, Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл, 1964, 100-р тал.

¹⁹ Н.Алтантөгс, Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний жилүүд дэх малчдын ядуурал ба улсын бэлтгэл – *Historia Mongolarum*, Улаанбаатар, 2014, 119-139-р талд дэлгэрэнгүй үз.

гүйцэтгэлээс үзвэл, зөвхөн 1956 онд БНМАУ-ын хэмжээнд амьдын жингээр нийт 106.3 мянган тонн малыг улсын бэлтгэлд цуглуулсан бөгөөд үүнээс үхэр 30.3 мянган тонн, хонь 59.9 мянган тонныг эзэлж байв. мөн 22.8 мянган тонн ноос, 113.8 сая литр сүүг улсын бэлтгэлийн хүрээнд малчдаас хураан цуглуулжээ.²⁰ Улсын бэлтгэлд нийлүүлж байсан малын тоо нь 1960 оны байдлаар улсын нийт мал сүргийн 11 хувийг эзэлж байв.²¹

БНМАУ-д социалист үйлдвэрлэлийн харилцаа оршин тогтнож байсан 1960-1990 оны 30 жилийн хугацаанд улсын бэлтгэлийн дотор мал (үхэр, хонь, ямаа, тэмээ), адуу, сүү, бүх төрлийн ноос гэсэн дөрвөн бүтээгдэхүүн тоо хэмжээ болон үнийн дүнгийн хувьд ихэнхийг эзэлдэг байв.

Улсын бэлтгэлийн гол бүтээгдэхүүнүүдийн хэмжээ

	1960	1970	1980	1990
Мал, мах (амьдын жингээр, мянган тонн)	135.6	144.4	195.5	175.3
Үүнээс: Үхэр	48.3	45.1	65.6	51.5
Хонь	69.0	82.5	105.4	102.0
Ямаа	18.3	16.8	24.5	21.8
Адуу, мянган толгой	38.8	88.1	101.2	45.9
Сүү, сая литр	93.7	64.9	92.4	144.4
Ноос, мянган тонн	23.6	26.7	27.7	26.8

Эх сурвалж: *БНМАУ-ын улс ардын аж ахуй 70 жилд (1921-1991)*, Улаанбаатар, 1991, 54-55-р тал (товчлов).

Жишээлэхэд, улс, ардын аж ахуй, соёлыг 1971-1975 онд хөгжүүлэх 5-р таван жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлээс бид 1966-1975 онууд дахь улсын бэлтгэлийн хэмжээ, далайц, гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг тодорхой харна. Эдгээрээс бид тухайн үед жил бүр бэлтгэж байсан улсын бэлтгэлийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний жилийн дундаж хэмжээг тооцож гаргавал дараах байдалтай.

²⁰ МУУТА, ф-8, д-3, хн-261, 14-15-р хуудас.

²¹ МУУТА, ф-8, д-3, хн-551, 2-р хуудас.

1966-1975 оны улсын бэлтгэлийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний нийт ба жилийн дундаж хэмжээ

	Хэмжих нэгж	1966-1970 он	Жилийн дундаж	1971-1975 он	Жилийн дундаж
Мал бэлтгэл (амьдын жингээр)	Тонн	671,723.5	134,344.7	841,711.9	168,342.38
Адуу	Толгой	385,961	77,192.2	421,236	84,247.2
Сүү	Сая литр	391.0	78.2	349.3	69.8
Бүх төрлийн ноос	Тонн	131,502.5	26,300.5	141,111.2	28,222.24

Эх сурвалж: МУУТА, ф-262, д-6, хн-652, 136-138-р хуудас.

Улсын бэлтгэл нь 1960-1990 онд хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй болон бусад хөдөө аж ахуйн улсын үйлдвэрийн газрууд, амины аж ахуй гэсэн гурван төрлийн нийлүүлэгчтэй байв. 1965 онд хөдөө аж ахуйн нэгдлүүд улсад бүх төрлийн мах 120.6 мянган тонн, бүх төрлийн ноос, ноолуур 17.8 мянган тонн, сүү 77.2 мянган тонныг тушааж байв.²² Улсын бэлтгэлийн гол нийлүүлэгчид 1970 оны байдлаар дараах хувь хэмжээг эзэлж байв.

Улсын төвлөрсөн бэлтгэлд аж ахуйн төрөл тус бүрийн эзлэх хувь
1970 он (хувиар)

Аж ахуйн төрөл	Улсын төвлөрсөн бэлтгэлд эзлэх жин (хувиар)			
	Төрөл бүрийн малын махны (хонь, үхэр, ямаа)	Төрөл бүрийн ноос ноолуурын (болдын хялгас орохгүй)	Үхрийн сүүний	Үр тарианы (улаан буудай)
1. Хөдөө аж ахуйн нэгдэл	81.6	76.7	85.7	29.0
2. Сангийн аж ахуй болон бусад хөдөө аж ахуйн улсын үйлдвэрийн газрууд	4.5	5.1	14.3	71.0
3. Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүд, сангийн аж ахуйн ажилчдын амины аж ахуй	13.9	18.2	-	-
Бүгд (хувиар)	100	100	100	100

Эх сурвалж: *Социалист хөдөө аж ахуйн эдийн засаг*, Улаанбаатар: УХГ, 1974, 264-р тал.

²² Хөдөө аж ахуйн нэгдэл, статистикийн эмхтгэл (1959-1965), Улаанбаатар, 1967, 32-33-р тал.

1976-1980 оны байдлаар хөдөө аж ахуйн нэгдлүүд жил бүр дунджаар 154.2 мянган тонн мах улсын бэлтгэлд нийлүүлж байсан²³ нь тухайн үеийн улсын нийт мал бэлтгэлийн 80 орчим хувийг эзэлж байв. Тухайлбал, 1978 оны байдлаар улсын хэмжээнд бэлтгэсэн нийт малын 72 хувийг нэгдлүүд, 5.2 хувийг САА, 22 хувийг амины малаас, 0.8 хувийг албан газраас нийлүүлжээ.²⁴

Ийнхүү хөдөө аж ахуйн нэгдлүүд нь 1970 онд улсын төвлөрсөн ба нийт бэлтгэлийн мал, махны 81.6 хувийг, ноос, ноолуурын 76.7 хувийг, үхрийн сүүний 85.7 хувийг, үр тарианы 29 хувийг, 1976-1980 онд улсын бэлтгэлийн нийт мал, махны 80 орчим хувийг нийлүүлж байсан бөгөөд хөдөө аж ахуйн нэгдлүүд нь сангийн аж ахуй, амины аж ахуйнуудтай харьцуулвал БНМАУ-ын улсын бэлтгэлийн мал аж ахуйн бүтээгдэхүүний голлох ханган нийлүүлэгч байжээ.

Улсын бэлтгэл нь БНМАУ-ын мал аж ахуйн таваарын борлуулалтыг бүхэлд нь хамарсан, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн үнэмлэхүй зах зээл байжээ. Энэ зах зээлд таваарын бүтээгдэхүүнээ борлуулах явдал БНМАУ-ын социалист мал аж ахуй эрхлэгчдийн, түүний дотор хөдөө аж ахуйн нэгдлүүдийн үндсэн чиг үүрэг болж байв.

Улсын бэлтгэл нь хөдөө аж ахуйн нэгдлүүдийн орлогын гол эх үүсвэр болохын зэрэгцээ хөдөө аж ахуйн нэгдлүүд нь улсын бэлтгэлийн гол ханган нийлүүлэгч байж, хөдөө аж ахуйн нэгдэл ба улсын бэлтгэл гэсэн хоёр тогтолцоо нь хоорондоо салшгүй уялдаатай оршиж байв. Ийм учраас хөдөө аж ахуйн нэгдлүүд мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүнээ улсын бэлтгэлд зориулан үйлдвэрлэж байжээ гэж үзэж болно.

Хөдөө аж ахуйн нэгдлүүд таваарын бүтээгдэхүүнийхээ дийлэнхийг улсын бэлтгэлд тушаах зорилгоор үйлдвэрлэж байсан бөгөөд энэхүү улсын бэлтгэл нь хөдөө аж ахуйн нэгдлүүдийн бүтээгдэхүүнийг, өргөн утгаараа монголын мал аж ахуйн бүтээгдэхүүнийг таваар болж хувиргах арга, хэрэгсэл байжээ.

Улсын бэлтгэлийн хүрээнд жил бүр бий болгож байсан мал аж ахуйн их хэмжээний нөөц баялаг нь бүхэлдээ улсын мэдэлд очиж байв. Тэдгээр баялгийг юунд зориулах, ямар салбарт, ямар үнээр хуваарилах нь улсын эрх мэдэлд хамаарч байв.

Улсын бэлтгэл энэ хэвээр үргэлжилсээр БНМАУ-д ардчилсан хувьсгал, өөрчлөлт шинэчлэлт эхэлсэн 1990 онтой золгосон билээ. 1990 онд “БНМАУ-ын Улс, ардын аж ахуй, соёлыг 1986-1990 онд хөгжүүлэх 8-р таван жилийн

²³ МУУТА, ф-262, д-6, хн-1112, 15-16-р хуудас.

²⁴ Д.Балжинням, Я.Шагдар, БНМАУ-ын хөдөө аж ахуйн нэгдэл, Улаанбаатар: УХГ, 1979. 29-р тал.

төлөвлөгөө” дуусгавар болж, мөн ондоо багтаан 1991-1995 онд хэрэгжих учиртай 9-р таван жилийн төлөвлөгөөг батлах байсан боловч ардчилсан өөрчлөлт, шинэчлэл өрнөв. Ингэснээр төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн улс, ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөө хэрэгцээгүй болж, уг таван жилийн төлөвлөгөөний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болж байсан улсын бэлтгэлийн үйл ажиллагаа ч зогсов.

Улсын бэлтгэл нь хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүний худалдан авагч биш, харин үйлдвэрлэгч болон хэрэглэгчид зэрэг худалдан авагчид дамжуулах завсрын зах зээл байв. Хөдөө аж ахуйн нэгдлийн үйлдвэрлэсэн таваарын бүтээгдэхүүн энэхүү улсын бэлтгэлийн тогтолцоогоор дамжин үндсэн хэрэглэгчиддээ хүрч байв.

Хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүний хэрэглээ

Бид хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын үйлдвэрлэлийн монополь худалдан авагч нь улсын бэлтгэл болох, улсын бэлтгэлийн гол ханган нийлүүлэгч нь хөдөө аж ахуйн нэгдэл болохыг авч үзсэн бөгөөд энэ байдал 1960-1990 онд өөрчлөгдөөгүй байна. Гэвч энэ нь хөдөө аж ахуйн нэгдлийн оршин тогтнолыг тэтгэгч макро нөхцлийг илрүүлэхэд хангалтгүй юм. Иймээс бид мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүн БНМАУ-ын нийт эдийн засагтай улсын бэлтгэлээр дамжин хэрхэн уялдаж байсныг авч үзэх шаардлагатай.

Мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний хэрэглэгч гэдэгт дотоод, гадаадын жижиглэн худалдааны дэлгүүрүүд, дотоод, гадаадын эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үйлдвэрүүд багтах бөгөөд үүнд БНМАУ-ын жижиглэнгийн худалдаа, төвийн болон орон нутгийн махкомбинатууд, сүү, тосны үйлдвэрүүд, мөн түүнчлэн ЗХУ-ын махкомбинатууд болон сүү, тосны үйлдвэрүүд зэрэг олон тооны аж ахуйн нэгжүүд худалдан авагчдын бүтэн тогтолцоог бүрдүүлж байв. Мөн эдгээр хэрэглэгчээс гадна улсын батлан хамгаалах салбар, гадаад хүмүүнлэгийн тусламж зэрэг эдийн засгийн бус зарцуулалт бий. Тухайлбал, БНХАУ, БНАСАУ, БНСВУ зэрэг улсуудад ган гачиг буюу дайн самуун тохиосон үед БНМАУ-аас хүмүүнлэгийн тусламж илгээхдээ улсын бэлтгэлийн нөөцөөс мал, ноос, түүхийг эд гаргаж байв. Гэвч эдгээр нь хөдөө аж ахуйн нэгдлийн өсөлт хөгжил, уналттай чухал уялдаа холбоогүй юм.

Улсын Төлөвлөгөөний Комиссын төлөвлөгөөнөөс үзвэл, 1980 онд улсын хэмжээнд үхэр, хонь, ямаа, тэмээний нийт 237.1 мянган тонн мал улсын бэлтгэлийн хүрээнд цуглуулахаас ЗХУ-д 35.0 мянган тонныг, Улаанбаатарын махкомбинатад

115.1 мянган тонн малыг нийлүүлэхээр төлөвлөж, уг төлөвлөгөөрөөр, улсын бэлтгэлийн нийт малын 14 хувийг экспортод, 48.5 хувийг махкомбинатад хуваарилжээ.²⁵ Уг төлөвлөгөө 1980 оны эхний хагас жил гэхэд 90-ээс дээш хувийн биелэлттэй хэрэгжиж байв.

1980 онд улсын бэлтгэлийн малыг хуваарилах төлөвлөгөө

	Улсын төвлөрсөн хэрэгцээнд бэлтгэх	Экспорт		Махкомбинатад тушаасан нийт мал	Жижиглэнгийн худалдаа болон бусад
		Нийт	Үүнээс: ЗХУ-д		
Дөрвөн төрлийн мал, амьдын жин, мянган тонн	237.1	35.0	35.0	115.1	87.0
Адуу, мянган толгой	101.4	76.0	76.0	25.4	

Эх сурвалж: МУУТА, ф-8, д-7, хн-860, 2-5-р хуудас.

Иймээс бид улсын бэлтгэлийн нөөцийг таваарын бүтээгдэхүүний тэр хэлбэрээр нь худалдан авдаг үндсэн гурван зах зээлийг авч үзнэ. Үүнд:

1. Шууд экспорт
2. Аж үйлдвэр
 - 2.1. Дотоод бүтээгдэхүүн
 - 2.2. Экспортын бүтээгдэхүүн
3. Жижиглэнгийн худалдаа

Шууд экспорт

Шууд экспорт гэдэг нь хөдөө аж ахуйн нэгдлүүдээс улсын бэлтгэлийн хүрээнд худалдан авсан мал, түүхий эдийг боловсруулахгүйгээр шууд тууварлах буюу тээвэрлэн гадаадад худалдах үйл ажиллагааг хэлнэ. БНМАУ-ын мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортод улсын бэлтгэлийн үндсэн бүтээгдэхүүнүүд голлох хувийг эзэлдэг байсан бөгөөд тухайлбал, 1960 оны нийт экспортод зөвхөн мал, ноос хоёр нийлээд 74.6 хувийг эзэлж байв.²⁶

Дэлхийн хоёрдугаар дайны дараа БНМАУ-д ихэнх аймаг, сумдыг хамарсан мал тууврын замын сүлжээ бий болов. Мал тууврын замын сүлжээнд 1954 оны байдлаар ЗХУ руу амьд мал тууварлан гаргадаг үндсэн дөрвөн чиглэл байв. Үүнд, Сэлэнгэ аймгийн Цагаан арал дамжлага бааз руу Сэлэнгэ, Төв, Булган,

²⁵ МУУТА, ф-8, д-7, хн-860, 5-р хуудас.

²⁶ БНМАУ-ын улс ардын аж ахуй 40 жилд, статистикийн эмхтгэл, Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1961, 127-р тал.

Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Говь-Алтай аймгууд, Хөвсгөл аймгийн Хатгал-Ханхын дамжлага бааз руу Хөвсгөл, Завхан аймгууд, Дорнод аймгийн Эрэнцавын боомт руу Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь аймгууд, Баян-Өлгий аймгийн хилийн дамжлага бааз руу Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудаас тус тус экспортын мал тууварладаг байв.²⁷ Тууврын замын энэ сүлжээнд 1960-1990 оны хооронд Дарханы махкомбинат байгуулагдах үед зарим үед өөрчлөлт орж, Хөвсгөл, Булган болон төвийн аймгууд шууд Дархан руу мал тууварлах болж өөрчлөгдөж байсан боловч ерөнхий чиглэл, сүрэглэх баазууд нь 1990 оныг дуустал онцын өөрчлөлтгүй байв. 1960-1990 оны хооронд тууврын хонь, үхрийн ихэнхийг дотоодын махкомбинатууд руу, харин адууны ихэнхийг ЗХУ-ын хилийн дамжлага баазууд руу тууварлаж байв.

Экспортод гаргасан зарим нэр төрлийн бүтээгдэхүүн

№		1960*	1970	1975	1980	1985	1990
1	Хонины угаасан ноос, мянган тонн	9.8	8.0	9.3	8.9	5.7	2.8
2	Мах, мянган тонн		20.9	35.7	45.9	36.8	24.3
	Мал, мянган тонн	102.0	51.0	50.2	36.1	24.7	20.8
	Нийт мал ба мах, мянган тонн		71.9	85.9	82.0	61.5	45.1
3	Адуу, мянган толгой		67.5	61.8	76.3	63.1	42.3

Эх сурвалж: БНМАУ-ын улс ардын аж ахуй 70 жилд (1921-1991), Улаанбаатар, 1991, 140-141-р тал.

* Зөвхөн ЗХУ-д гаргасан экспорт. Эх сурвалж: *Внешняя торговля СССР, Статистический сборник, 1918-1966*, Москва: Международные отношения, 1967, сс. 216-217.

Улсын бэлтгэлийн хүрээнд бүрдүүлсэн адууны 75-92 хувь нь тогтмол экспортод гарч байсан бөгөөд үүний шалтгаан нь монголчуудын махны хэрэглээний онцлогоос шалтгаалж адууны махны дотоодын хэрэглээ маш бага төвшинд байсантай холбоотой. 1980 онд Улаанбаатарын махкомбинатад улсын бэлтгэлээс 1190 тонн адуу нийлүүлэх, түүнээс 547.5 тонн мах үйлдвэрлэн, уг адууны махыг бүгдийг дотоодод хиам, консерв үйлдвэрлэхэд зарцуулахаар төлөвлөж байсан бол бусад ихэнх адууг амьдаар нь ЗХУ-д экспортлохоор төлөвлөжээ.²⁸

БНМАУ-аас ЗХУ-д гаргах экспортын ихээхэн хувь нь амьд мал байв. Амьд малыг ЗХУ-д “Скотоимпорт” нэгдэл хариуцан хүлээн авч, цааш махкомбинатуудад хуваарилдаг байв. Скотоимпорт нэгдлийн Улаан-Үдийн контор БНМАУ-ын Төв болон Дорнод хэсгийн мал тууврыг, Хэрэнгийн контор Хатгал-Ханхын мал

²⁷ МУУТА, ф-17, д-1, хн-519, 154-р хуудас.

²⁸ МУУТА, ф-8, д-7, хн-860, 5-р хуудас.

тууврыг, Бийскийн контор баруун аймгуудын мал тууврыг тус тусын хил дээрх дамжлага баазуудаараа дамжуулан хүлээн авч байв. 1977 оны байдлаар ЗХУ-ын Скотоимпорт нэгдэл гадаадаас нийт 128.3 мянган тонн амьд мал импортолсны дотор БНМАУ-аас Улаан-Үдийн контор 29.0, Хэрэнгийн контор 15.0, Бийскийн контор 14.6 мянган тонн амьд малыг импортлон авсан бөгөөд Словактай хиллэдэг Украины Ужгород дахь контор хамгийн их буюу 68.1 мянган тонн амьд мал импортолж, түүний удаад БНМАУ-аас импортолсон амьд мал орж байжээ.²⁹

Скотоимпорт нэгдлийн Улаан-Үдийн контор БНМАУ-аас импортлон авсан малаа Улаан-Үдийн махкомбинат, Эрхүүгийн махкомбинат, Наушкийн махкомбинат гэсэн гурван үйлдвэрт, Хэрэнгийн контор Эрхүүгийн махкомбинатад, Бийскийн контор Томск зэрэг хотуудын махкомбинатуудад тушаадаг байв. Эдгээр конторуудаас БНМАУ-аас хамгийн их мал худалдан авдаг Улаан-Үдийн контор малаа голлон Улаан-Үдийн махкомбинатад тушааж байсан бөгөөд 1968 оны дүн мэдээгээр тус контор БНМАУ-аас 16 мянган үхэр, 193 мянган хонь, ямаа, 51 мянган адуу импортлон авсан бөгөөд үүнээс Улаан-Үдийн махкомбинатад 14 мянган үхэр, 187 мянган хонь, ямаа, 51 мянган адууг тушаажээ.³⁰

Хөдөө аж ахуйн нэгдлүүдийн үндсэн хэрэглэгчдийн нэг нь ЗХУ-ын Сибирийн мах комбинатууд байсан бөгөөд гэвч хөдөө аж ахуйн нэгдлүүдийн борлуулалтын зах зээлд эзлэх ЗХУ-ын мах комбинатуудын үүрэг роль буурсаар байжээ.

Улсын бэлтгэлийн голлох бүтээгдэхүүнд экспортын эзлэх хувь

	1960	1970	1980	1990
Улсын бэлтгэлийн малд экспортын малын эзлэх хувь	75.2	35.3	18.4	11.8
Улсын бэлтгэлийн адуунд экспортын адууны эзлэх хувь		76.6	75.3	92.1
Улсын бэлтгэлийн ноосонд экспортын угаасан ноосны эзлэх хувь	41.5	29.9	32.1	10.4

* Зөвхөн ЗХУ-д гаргасан экспорт

1960 онд улсын бэлтгэлийн хүрээнд цуглуулсан нийт малын 75.2 хувийг шууд тууварлан шууд экспортод гаргаж байсан бол 1980 онд ердөө 18.4 хувийг шууд экспортод гаргадаг болжээ. Энэ байдал мөн ноосон дээр мөн адил юм. 1960-1990 оны хооронд адуунаас бусад мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүнийг шууд экспортлох явдал тогтвортой багасч байв.

²⁹ Государственный Архив Республики Бурятия, ф. р-662, оп. 1, д.498, сс.19.

³⁰ Государственный Архив Республики Бурятия, ф. р-662, оп. 1, д.365, сс.7.

Аж үйлдвэр дэх хэрэглээ

БНМАУ-д 1980-аад онд дотоодын аж үйлдвэр бодит байдал болж, мал аж ахуйн гаралтай хэд хэдэн төрлийн эцсийн бүтээгдэхүүн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг их хэмжээгээр үйлдвэрлэн гаргаж эхэлжээ. Ноосыг боловсруулан хивс, эсгий гутал, ноосон даавуу, махыг боловсруулан үйлдвэрийн мах буюу лаазалсан бүтээгдэхүүн, хиам, сүүг боловсруулан казейн, хонь, ямааны арьснаас шеврет, шевро зэрэг хагас боловсруулсан буюу эцсийн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэх болсон байна.

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

	1940	1960	1970	1980	1985	1990
Угаасан ноос, мянган тонн	1.7	5.6	9.8	11.8	11.3	9.7
Хивс, мянган м ²		1.1	8.6	464.4	1585.8	2017.1
Эсгий, мянган м	135.9	295.2	550.2	614.6	623.9	745.0
Эсгий гутал, мянган хос	84.1	76.7	394.2	465.8	452.2	596.7
Ноосон даавуу, мянган тууш м	46.7	229.1	623.7	963.5	1432.5	1111.3
Савхин гутал, мянган хос	163.3	904.3	1621.5	2104.9	2883.4	4806.1
Савхин дээл, мянган ш		11.0	47.0	53.3	81.0	35.5
Нэхий дээл, мянган ш				83.0	135.2	137.2
Мах, махан бүтээгдэхүүн, мянган тонн	4.8	12.8	34.9	56.8	62.5	59.0
Хиамны зүйл, тонн	388.0	659.0	683.5	2966.1	4051.5	5629.5
Сүү, сүүн бүтээгдэхүүн, сая л		7.7	10.8	24.8	45.2	61.5

Эх сурвалж: БНМАУ-ын улс ардын аж ахуй 70 жилд (1921-1991), Улаанбаатар, 1991, 66-67-р тал.

1970-аад онд Улаанбаатарын махкомбинатыг шинэчилж, мөн Дарханы мах комбинат ашиглалтад оров. 1980 он гэхэд Улаанбаатар, Чойбалсан, Дарханд махкомбинатууд ажиллаж байв. Улсын хэмжээнд гурван том мах комбинат ажиллаж эхэлснээр БНМАУ-ын мал, махны борлуулалтад өөрчлөлт гарч, 1960 онд нийт бэлтгэсэн малын 75.2 хувийг шууд экспортод гаргаж байсан бол 1990 он гэхэд энэ тоо 11.8 хувь болон буурч, түүний ихэнхийг дотоодын мах комбинатуудад тушаах болжээ.

1980 онд махкомбинатуудад 49.5 мянган тонн мах үйлдвэрлэн гаргахаар төлөвлөж байсан бөгөөд дотоодын хэрэгцээнд үүнийхээ 14.4 мянган тонныг борлуулах бол экспортод 34.4 мянган тонныг гаргаж, тусгай нөөцөд 600 тонныг авахаар төлөвлөж байв. Үүнээс үзэхэд, махкомбинатад үйлдвэрлэсэн махныхаа 69.4 хувийг ЗХУ болон Зүүн Европын улсуудад экспортлохоор төлөвлөж байжээ.³¹

³¹ МУУТА, ф-8, д-7, хн-860, 3-4-р хуудас.

Махкомбинатад үйлдвэрлэх махыг хуваарилах төлөвлөгөө, 1980 он

	Гурван төрлийн мал	Адуу	Бүгд
Махкомбинатад нийлүүлэх мал, амьдын жин, мянган тонн	113.9	1.1	115.1
Үйлдвэрлэх мах, мянган тонн	48.9	0.5	49.5
Дотоодод хуваарилах, мянган тонн	13.9	0.5	14.4
Экспортлох, мянган тонн	34.4	-	34.4
Тусгай нөөц, мянган тонн	0.6	-	0.6

Эх сурвалж: МУУТА, ф-8, д-7, хн-860, 5-р хуудас.

1960-аад оноос өмнө БНМАУ-ын экспортод угаасан ноос чухал байр суурь эзэлдэг байсан бөгөөд 1970-80-аад онуудад Улаанбаатар, Хатгал, Чойбалсан, Өлгий хотуудад ноос угаах үйлдвэрүүд эрчимтэй үйл ажиллагаа явуулах болж, угаасан ноосны борлуулалт дотоодын ноосон нэхмэлийн үйлдвэрүүд рүү чиглэж эхэлжээ.

БНМАУ 1960 онд таваар болгон бэлтгэсэн нийт ноосны 41.5 хувийг ЗХУ-д экспортолж байсан бол 1990 он гэхэд экспортолсон угаасан ноос нь нийт таваарын ноосны ердөө 10.4 хувийг эзлэх болж багассан бөгөөд ихэнх ноосыг дотоодын ноос угаах үйлдвэрүүд, хивс, ноосон эдлэлийн үйлдвэрүүдэд тушааж, нэмүү өртөг шингэсэн эцсийн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх болжээ.

Эдгээрээс үзэхэд, улсын бэлтгэлийн бүтээгдэхүүний хэрэглээнд 1960-1990 онд том өөрчлөлт гарчээ. Хагас боловсруулсан ямааны арьс-шевро, хагас боловсруулсан хонины арьс-шеврет, савхин хувцас нь улсын бэлтгэлийн хонь, ямаа, үхрийн арьснаас, ноосон хөнжил нь улсын бэлтгэлийн ноосноос, мах нь улсын бэлтгэлийн үхэр, хониноос бүрдэж байв. Аж үйлдвэр хөгжсөнөөр өмнө нь шууд экспортод гаргадаг байсан мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний ихэнхийг дотооддоо үйлдвэрийн түүхий эд болгон ашиглаж эхлэв.

Экспортын үйлдвэрлэл

БНМАУ нь хөдөө аж ахуйн нэгдлүүдийн нөөц бололцоонд түшиглэн ихээхэн мах үйлдвэрлэгч, экспортлогч болон хувирсан байв. Экспортын мах гэдэг нь улсын бэлтгэлийн малыг дотоодын үйлдвэрт тушааж, улмаар мах комбинатуудад боловсруулан хөлдөөж, уг хөлдөөсөн махны нэг хэсгийг гадаадад экспортолсон дүн юм. Экспортын мах нь улсын бэлтгэлийн бүтээгдэхүүний экспорт биш, харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортод хамаарах боловч түүний үндсэн түүхий эд нь хөдөө аж ахуйн нэгдлүүдээс улсын бэлтгэлд тушаасан амьд мал байв.

БНМАУ-ын амьд малын экспорт зөвхөн ЗХУ-д гарч байсан бол үйлдвэрийн махны экспортын ихэнх ЗХУ-д харин үлдсэн бага хэсэг нь Зүүн Европын социалист улсуудад ногдож байв. тухайлбал, Улсын Төлөвлөгөөний Комиссоос 1980 онд мал, мах экспортлохоор гаргасан судалгаанаас үзвэл, ЗХУ-д 35 мянган тонн амьд мал, 76 мянган толгой адуу, 41 мянган тонн үйлдвэрийн мах гаргахаар төлөвлөсөн бол харин БНБАУ, БНАГУ, БНПАУ, БНСЧСУ, БНУАУ, ХБНСЮУ-уудад нийт 6.5 мянган тонн үйлдвэрийн мах экспортлохоор төлөвлөсөн бөгөөд улсын хэмжээгээр нийт 47.5 мянган тонн үйлдвэрийн мах экспортлох ажээ.³²

Доорх хүснэгтэд Монголын мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүнийг хэрэглэж үйлдвэрлэсэн аж үйлдвэрийн зарим нэр төрлийн барааны экспортын хэмжээг 1990 ба 1995 оны байдлаар харьцуулан үзэв.

БНМАУ-ын зарим аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт

	1990	1995
Шевро, мянган ширхэг	172.0	0.0
Шеврет, мянган ширхэг	24.1	0.1
Савхин хувцас, мянган ширхэг	87.0	0.8
Хивс, сая м ²	1.7	0.0
Ноосон хөнжил, мянган ширхэг	336.4	20.5
Мах, мянган тонн	24.3	2.2

Эх сурвалж: *Монгол улсын статистикийн эмхтгэл, 1999 он*, Улаанбаатар: 2000, 146-р тал.

1990 оноор жишээ болговол, улсын хэмжээнд 59 мянган тонн мах үйлдвэрлэсний 24.3 мянган тонныг, 2 сая м² хивс үйлдвэрлэсний 1.7 сая м²-ыг тус тус экспортод гаргаж байжээ. 1990 онд зөвхөн шевро 172 мянган ширхгийг экспортолж байв.

Жижиглэнгийн худалдаа

Улсын худалдаа нь улсын бэлтгэлийн ба аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нөөцөөр дотоодын хэрэглээг хангах үндсэн арга байв. Улсын дэлгүүрүүд улсын бэлтгэлээс болон үйлдвэрүүдээс мах, сүү болон бусад бараа таваарыг хүлээн авч, гадаадаас импортлон оруулсан зүйлстэй нийлүүлэн иргэдэд жижиглэнгээр худалддаг байв.

³² МУУТА, ф-8, д-7, хн-860, 3-р хуудас.

Улсын худалдаагаар хүн амд худалдсан хүнсний зарим
нэр төрлийн бүтээгдэхүүн

	1960	1970	1980	1985	1990
Мах, махан бүтээгдэхүүн, мянган тонн	6.5	30.3	48.2	59.7	72.5
Үүнээс: малын мах	5.3	28.4	38.1	43.0	55.0
Сүү, сая литр		11.9	29.1	36.0	35.0

Эх сурвалж: БНМАУ-ын улс ардын аж ахуй 70 жилд (1921-1991), Улаанбаатар, 1991, 90-91-р тал.

Монголчууд улсын дэлгүүрээс нийт мах, махан бүтээгдэхүүн 1990 оны байдлаар 72.5 мянган тонн, үүнээс малын мах 55 мянган тонн, сүү 35 сая литр худалдан авч хэрэглэсэн бөгөөд мах комбинатууд үүний багахныг нийлүүлж, харин үүний ихэнх нь улсын бэлтгэлийн нөөц, хөдөө аж ахуйн нэгдлийн болон импортын махан бүтээгдэхүүнээс бүрдэж байв.

1960-1990 онд БНМАУ-ын дотоодын жижиглэнгийн худалдаалсан мах 10 гаруй дахин, сүү 3 дахин нэмэгдсэн явдал нь төв суурин газрууд томорч, хот, хөдөөгийн хооронд улсын бэлтгэлээр дамжуулан таваарын худалдаа эрчимтэй хөгжиж байсныг харуулна. Энэ нь бүхэлдээ худалдаанд тогтоосон төрийн монополь эрх, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн байгуулалд үндэслэж байв.

ЗХУ руу чиглэсэн экспорт

БНМАУ-ын нийт экспортын гол худалдан авагч ЗХУ байсан бөгөөд БНМАУ эрчимтэй аж үйлдвэржихээс өмнө экспортын ихэнх бүтээгдэхүүн, түүний дотор хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын ихэнх бүтээгдэхүүн ЗХУ-д гарч байв. 1956 онд 225.9 сая төгрөгийн экспорт хийснээс ЗХУ-д 210.3 сая төгрөгийн экспортыг гаргажээ.³³

1960-1990 оны хооронд БНМАУ-ын нийт экспортын 68-79 хувь нь зөвхөн ЗХУ-д гарч байв. Ялангуяа шевро, шеврет, казеин зэрэг мал аж ахуйн гаралтай эцсийн ба хагас боловсруулсан бүтээгдэхүүн бараг тэр чигтээ ЗХУ руу гарч байв. Иймээс БНМАУ-ын экспортын орлого нь үндсэндээ ЗХУ-тай хийх худалдаанаас хамаарч байсан гэж хэлж болно.

³³ МУУТА, ф-8, д-3, хн-261, 14-р хуудас.

БНМАУ/Монгол улсын экспортод ЗХУ/ОХУ-ын эзлэх хувь, 1951-1995
сая ам. доллар

	1951	1960	1970	1980	1989	1990	1995
Нийт экспорт	9.4	16.3	84.4	402.8	721.5	660.7	473.3
ЗХУ/ОХУ-д гаргасан экспорт	9.4	12.4	57.7	319.6	528.4	519.6	68.9
Нийт экспортод ЗХУ/ОХУ-ын эзлэх хувь	100	76	68	79	73	78	14

Эх сурвалж: *Монгол Улс 100 жилд (1911-2011), Статистикийн эмхэтгэл*, Улаанбаатар, 2012, 171-185-р тал (түүвэрлэн авав).

БНМАУ-д аж үйлдвэрийн салбар эрчимтэй хөгжих болсноор хөдөө аж ахуйн нэгдлүүдийн таваарын бүтээгдэхүүн шууд экспортод гардаг байдал багасч, дотоодын үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах явдал хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүний үндсэн урсгал болон хувирчээ.

БНМАУ-д 1989-1990 онд өрнөсөн ардчилсан хувьсгал, зах зээлийн нийгэмд шилжих шилжилтийн үеэр улсын бэлтгэл зогссон явдал хөдөө аж ахуйн нэгдлүүд тарах гол шалтгаан болжээ. Улсын бэлтгэл зогссон явдал нь БНМАУ-ЗХУ-ын эдийн засгийн интеграци 1990 онд дуусгавар болсноос шалтгаалсан билээ.

Дүгнэлт

1. Хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүний борлуулалт нь улсын бэлтгэл дээр оршиж байв. Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг таваар болгон эцсийн хэрэглэгчид хүргэх борлуулалтын нэгдмэл тогтолцоонд орсон явдал нь хөдөө аж ахуйн нэгдлүүд таваар үйлдвэрлэгч байх гол орчинг бүрдүүлжээ.
2. Социализмын эхэн үед мал, түүхий эдийг шууд ЗХУ-д экспортолж, түүнийг нь ЗХУ-ын үйлдвэрүүд эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж байсан бол 1970-аад оноос эхлэн 1990 оныг хүртэлх социализмын ихэнх хугацаанд мал, түүхий эдийн дийлэнхийг дотоодын аж үйлдвэрт нийлүүлэх болжээ. Хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүний хэрэглээнд үндсэн хоёр үе ажиглагдав.
 - a. 1960-1970-аад он - Шууд экспорт давамгайлсан үе
 - b. 1970-аад оноос 1990 он - Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн давамгайлсан үе
3. БНМАУ-ын хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүний эцсийн хэрэглээнд 1960-1990 оны хооронд хувьсгалт гэмээр том өөрчлөлт гарсан байна. Хөдөө аж ахуйн нэгдлийн үндсэн зах зээл 1960-1990 онд шууд

экспортоос дотоодын аж үйлдвэр болон жижиглэнгийн худалдаа рүү шилжжээ. 1980-аад он гэхэд хөдөө аж ахуйн нэгдлүүд мала аж ахуйн таваарын бүтээгдэхүүнээ улсын бэлтгэлд тушааж, улсын бэлтгэлд бүрдсэн тэрхүү нөөцөөс дотоодын мах комбинатууд, хувцас, арьс ширний үйлдвэрүүдэд ихэнхийг нийлүүлж, тэдгээрээр үйлдвэрүүдэд эцсийн бүтээгдэхүүн буюу хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зарим бүтээгдэхүүнийхээ бараг ихэнхийг тэр чигээр нь экспортод гаргадаг тогтолцоо БНМАУ-ын социалист эдийн засагт бүрдээд байв.

4. Хөдөө аж ахуйн нэгдлүүд таваар үйлдвэрлэгч хэлбэрээр оршин тогтнох эдийн засгийн суурь хүчин зүйл нь ЗХУ-д гаргах экспорт байжээ. 1990 оноос Зөвлөлт-Монголын эдийн засгийн интеграц тасарч, үүний улмаас улсын бэлтгэлийн тогтолцоо нуран унасан явдал Монголын мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүнд хүчтэй цохилт болж, улмаар Монголын мал аж ахуй 30 жилийн өмнөх эдлэхүүний аж ахуй руугаа ухран орох үндсэн нөхцөл болсон бололтой.
5. Цаашид эдгээр дүгнэлтийг нягтлахын тулд энэхүү тогтолцоон дахь олон төрлийн үнийн асуудлыг цаашид нарийвчлан судлах шаардлага бий.

Abstract

The Agricultural Cooperation's livestock commodity primary market in MPR was the *ulsiin beltgel* (government enforced purchase). The main consumers of the Agricultural Cooperation's livestock commodity were factories of the MPR and USSR. The main factor for existence of Agricultural Cooperation was economic integration between MPR and USSR.

Номзүй

1. *Хөдөө аж ахуйн нэгдэл, статистикийн эмхтгэл (1959-1965)*. Улаанбаатар, 1967.
2. *Хөдөө аж ахуйн нэгдлийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн эмхтгэл*. Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар, 1988.
3. *БНМАУ ба социалист орнуудын эдийн засгийн түүх*. Улаанбаатар, 1984.
4. *Монгол улсын түүх*. Б. 5. Улаанбаатар, 2003.
5. Пэлжээ, М. *Бүгд Найрамдах Монгол Ард Улс дахь таваарын үйлдвэрлэл ба худалдаа*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл, 1964.
6. Намжим, Т. *БНМАУ-ын эдийн засгийн түүх*. Улаанбаатар, 1986.
7. *БНМАУ-ын түүх*. Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар, 1966.
8. *БНМАУ-ын хөдөө аж ахуй 50 жилд*. Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар, 1971.
9. *БНМАУ-ын хөдөө аж ахуй 60 жилд*. Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар, 1982.

10. *Внешняя торговля СССР, Статистический сборник, 1918-1966.* Москва: Международные отношения, 1967.
11. *БНМАУ-ын социалист хөдөө аж ахуйн зарим асуудал.* Улаанбаатар, 1976.
12. Жадамба, Д. *Монголын мал аж ахуй XX зуун.* Улаанбаатар, 2003.
13. Энгельс, Ф. *К.Маркс. Улс төрийн эдийн засгийн ухааныг шүүмжлэх нь.* Б. 1, *Түүвэр зохиол-д,* Ф.Энгельс К.Маркс-ээр. Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар, 1969.
14. *Нэгдлийн малчны лавлах.* Улаанбаатар, 1975.
15. *Народное хозяйство МНР за 60 лет, юбилейный статистический сборник.* Улан-Батор, 1981.
16. Цэдэнбал, Ю. *Социализм байгуулах чиг шугам, гадаад бодлого.* Улаанбаатар, 1968.
17. *Социалист хөдөө аж ахуйн эдийн засаг.* Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар, 1974.
18. Цагаанхүү, Р. *Хөдөө аж ахуйн нэгдлийн мал аж ахуйн бүтээгдэхүүний өөрийн өртгийн асуудалд.* Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл, 1968.
19. Балжинням, Д., Шагдар, Я. *БНМАУ-ын хөдөө аж ахуйн нэгдэл.* Улаанбаатар, 1979.
20. *Хорьдугаар зууны Монгол (Түүхэн тойм).* Улаанбаатар, 1995.
21. Лувсандорж, П. *БНМАУ-ын социалист эдийн засгийн түүх.* Улаанбаатар, 1986.
22. Kotkin, Stephan, ба Bruce A.Elliman, . *Mongolia in the Twentieth Century: Landlocked Cosmopolitan.* New York: Armonk, 1999.
23. Murphy, G.S. *Soviet Mongolia: A Study of the Oldest Political Satellite.* Berkeley: University of California Press, 1966.
24. Robert, R. *The Mongols of the Twentieth Century.* Bloomington: Indiana University Publications, 1964.